



**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

“Евразия капитал холдинг ҮЦК” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4-р сарын 27-ны өдөр 12 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпын гудамж, Реженси Резиденс байр 3-р давхарт 314 тоот өрөөнд эхлэв.

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч нийт ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Энэхүү хуралд компанийн хувьцаа эзэмшигчид болох иргэн Г.Оюунболд, “Евразия капитал холдинг ҮЦК”ХК, “Мезза Файнэншл Групп” ХХК, “Омега Инвест” ХХК, “Вистекс Глобал Инвест” ХХК, нар оролцсон бөгөөд нийт 2 249 814 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 2 270 892 ширхэг энгийн хувьцааны 99.07% болж хурал хүчин төгөлдөр эхлэв.

Хурлын дарга Г.Оюунболд:

- Хурлыг нээж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:
 1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 2. Компанийн 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
 4. Бусад.

Хурлаар хэлэлцэх асуудлаа нэг бүрчлэн авч хэлэлцээд тухай бүрд нь асууж тодруулах зүйлээ асууя гэсэн саналтай байна. Та бүхэн юу гэж бодож байна?

Хуралд оролцогчид:

- Зөвшөөрч байна.

Хурлын дарга Г.Оюунболд:

- “Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан” – гийн талаар компанийн Гүйцэтгэх захирал Г.Оюунболд миний бие танилцуулъя. Мөн ТУЗ-ийн дүгнэлт ч та бүхэнд танилцуулагдах болно.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тус компани нь 2017 онд хоёр зуун арван есөн сая төгрөгийн арилжаа хийсэн байна. Хоёр компанийн нэмж гаргах үнэт цаасны ажлыг эхлүүлээд байна. Манай хөрөнгө оруулагчид, сангууд Монголоос гарсан хэдий ч бид үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр дахин хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулагчидтай холбоо тогтоон ажиллаж байна.

Бид татан төвлөрүүлэхээр төлөвлөөд зөвшөөрлөө авсан байсан таван тэрбум төгрөгийг гадны хөрөнгө оруулагч нараас татан төвлөрүүлэх бүрэн боломж 2017 онд байсан. Санхүүгийн Зохицуулах Хорооноос хариу шийд өгөхгүй байсаар манай хөрөнгө

оруулагч нар Монголоос гарч бидэнд ихээхэн хохирол учирсанг та бүхэн мэдэж байгаа. Хэрвээ тэр мөнгийг татан төвлөрүүлсэн байсан бол бид өнгөрсөн жил хувьцааны арилжаанд маш сайн оролцох цаашлаад манай ашиг орлого ч сайн байх байлаа. Мөн бид шинээр хийгдэх IPO-нд амжилттай оролцох бүрэн боломж байсан. Санхүүгийн Зохицуулах Хорооны буруу гэж ойлголгүй харин манай компанийг хөрөнгөө босгож чаддаггүй гэсэн яриа гарч бидний нэр хүнд унасан харамсалтай жил болж өнгөрлөө. Төрийн эрх бүхий байгууллага нь ямар ч хариу өгөлгүй, таг дуугай байсаар, очиж уулзахаар би ч мэдэхгүй, тэрэнтэй уулз, энэнтэй уулз гэсэн хүмүүстэй бүтэн жил зууралдлаа.

Бид нэмэлт хувьцаа гаргах замаар хувьцааныхаа төвлөрлийг бууруулах, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр брокер дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, BNY Mellon банкттай хамтран хадгаламжийн бичиг /Depositary receipt/-ийг нэвтрүүлэх, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/ хэрэгжүүлэх, өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг зорилгоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй /Санхүүгийн Зохицуулах Хорооны үнэлгээний газраас нэгж хувьцааны үнийг 540 төгрөгөөр тогтоосон/ 200 000 000 /хоёр зуун сая/ ширхэг хувьцаа нэмж гаргахаар 2015 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн гэдгийг та бүхэн маань мэдэж байгаа байхаа.

2015 оны 07-р сарын 27-нд анх хүсэлт гаргаад түүнийгээ шинэчлэн 10-р сарын 23 өдөр 111 тоот албан бичгээр хүсэлт гарган үнэт цаасны танилцуулгаа хүргүүлсэн. Хөрөнгө оруулагчдын Монголд итгэх итгэл сул, эдийн засгийн байдал муу, гадны хөрөнгө оруулагчид болон хөрөнгө оруулалтын сангуудын Монголд хөрөнгө оруулалт хийх боломж бололцоо зэргийг харгалзан үзээд эхний ээлжинд буюу 2016 ондоо 50 000 000 ширхэг хувьцааг эхлэн гаргахаар шийдвэрлэсэн.

2015 оны 12-р сарын 17-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны хурлаар манайд эхний ээлжинд таван тэрбум төгрөгийн буюу 50 000 000 ширхэг хувьцаа гаргахыг зөвшөөрч энэхүү тавин сая ширхэг хувьцааг амжилттай гаргасан тохиолдолд дараагийн 150 000 000 ширхэг хувьцаа нэмж гаргах зөвшөөрлийг олгохоор болсон.

Ингээд бид 2015 оны 12-р сарын 17-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны хурлын 419 тоот тогтоолоор 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй тавин сая ширхэг хувьцаа нэмж гаргах зөвшөөрлийг албан ёсоор авсан.

Үүний дараа бид “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-д 2016 оны 01-р сарын 08 өдөр 16/03 тоот албан бичгээр нэмж хувьцаа гаргах үнэт цаасны танилцуулгаа хүргүүлэн бүртгэж өгөхийг хүссэн. Энэхүү хүсэлтээ албан ёсоор хүргүүлснээс хойш Монголын Хөрөнгийн Биржийн Захиралтай, бүртгэлийн хэлтэсийнхэнтэй /Тогтохбаяр, Нямдорж нар/ уулзаж нөхцөл байдлын талаар ярилцаж байсан. Нэг өдөр Тогтохбаяр дарга над руу утасдаж бид танай материалыг хянаж үзлээ. Манай захирал Болор тантай уулзаж ярилцах хэрэгтэй байна гэсэн. Тэгээд намайг очиход Болор захирал “Монголд хадгаламжийн бичиг буюу DR хэрэгжих болоогүй байна. Тиймээс хадгаламжийн бичигт зарцуулах хөрөнгөө арилжаанд буюу брокер дилерийн үйл ажиллагаандаа түлхүү оруулах хэрэгтэй байна гэсэн санал тавьсан. Тэгэхэд нь бид компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдэгдэж Санхүүгийн Зохицуулах Хороогоор шалгагдан хурлаар нь орж батлагдсан үнэт цаасны танилцуулгад өөрчлөлт оруулах эрх надад байхгүй, тэгээд ч энэ боломжгүй хууль бус үйлдэл. Хадгаламжийн бичиг буюу DR гэх шинэ санхүүгийн хэрэгсэл шинэ үнэт цаасны хуульд тусгагдаасай гэж хүлээж байсан. ТУЗ-даа танилцуулъя гэдгээ хэлсэн. Монголын Хөрөнгийн Биржийн зүгээс тэгвэл өөрчлөлт оруулахгүй бол манайх шийдвэрлэх боломж байхгүй эсвэл та нар Санхүүгийн Зохицуулах Хороонд хандаад үнэт цаасны танилцуулгандаа нэмэлт өөрчлөлт оруулаад ир гэсэн хариуг өгсөн.

Дахиж Санхүүгийн Зохицуулах Хороонд хандан нэмэлт өөрчлөлт хийлгүүлэх ямар ч боломжгүйг бид мэдэж байсан тул ойлголцох гэж их явсан. 2016 оны 04-р сарын 08-ны өдөр намайг эзгүй байх үед миний ажлыг орлож байсан манай ахлах шинжээч маань ТУЗ-ийн даргатай ярилцаж байгаад “Монголын Хөрөнгийн Бирж” ХК шийдэж өгөхгүй удаад байна гэсэн үндэслэлээр хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө хийн хүргүүлсэн байсан. Харин үүнийг Гүйцэтгэх Захирал Г.Оюунболд миний бие эсэргүүцэж Хөрөнгийн Биржийн Захирал Болортой биечлэн уулзаж хууль бус гэдгийг тайлбарлан, тэрээр ойлгон хүлээн авч зөвшилцсөнөөр манай асуудлыг СЗХ-ны баталснаар шийдвэрлэхээр болсон юм.

Ингээд 2016 оны 05-р сарын 19 өдрийн 197 тоот “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн захирлын тушаал гарч манай үнэт цаасыг албан ёсоор бүртгэсэн болно.

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн Үнэт Цаасны Бүртгэлийн Журмын 8.2 /Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу МХБ ТӨХК нь тухайн үнэт цаасыг биржийн бүртгэлд бүртгэсэн тухай болон арилжааг эхлүүлэх бэлтгэлийг хангасан тухай тодорхойлолтыг, үнэт цаас гаргагч нь арилжаа эхлүүлэх тухай хүсэлтийг тус тус СЗХ-нд бичгээр мэдэгдсэний үндсэн дээр үнэт цаасны анхдагч зах зээлд уг үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг СЗХ олгоно/ болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2-т зааснаар /Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг Хороо олгох бөгөөд Хороо уг зөвшөөрлийг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай хөрөнгийн биржээс гаргасан тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн олгоно/ “Монголын Хөрөнгийн Бирж” ХК үнэт цаасыг биржийн бүртгэлд бүртгэсэн тухай болон арилжааг эхлүүлэх бэлтгэлийг хангасан тухай тодорхойлолтыг хууль, журмынхаа дагуу Санхүүгийн Зохицуулах Хороонд явуулсан гэж бид бодож байсан. Энэ бол тэдний гүйцэтгэвэл зохих үйл ажиллагааны нэг хэсэг.

Үүний дараа бид Хөрөнгийн Биржид хандан тэдний 2 давхарын танхимыг түрээслэн танилцуулгаа хийсэн.

СЗХ-ны бүртгэлийн журмын 4.4.3-т заасны дагуу ажлын 3 хоногийн өмнө бид СЗХ-нд /2016 оны 06-р сарын 13 өдөр, дугаар 16/59/ болон МХБ -нд /2016 оны 06-р сарын 13 өдөр, дугаар 16/60/ албан бичгүүдээр арилжаа эхлүүлж өгнө үү гэсэн хүсэлтээ албан ёсоор хүргүүлсэн. МХБ-д энэхүү албан бичгээ өгөхөөр очиход танайх СЗХ-ноос арилжаа эхлүүлэх зөвшөөрлөө аваад ир гэж явуулсан.

Бид шаардлагын дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооноос арилжаа эхлүүлэх зөвшөөрөл хүсэн удаа дараа Санхүүгийн Зохицуулах Хороонд очсон боловч эрх бүхий этгээдүүд ажилдаа ирээгүй, хөдөө явсан байна гэдэг шалтгаанаар бидэнд ямар нэгэн хариу болон зөвшөөрлийг өгөөгүй. Энэ асуудлаар намайг хөөцөлдөн явж байхад Үнэт цаас гаргалтын газрын дарга Ш.Түмэнбаяр мэргэжилтэн Хишгээ, дэд дарга Тулга нар ажиллаж байсан. 2016 оны 06-р сарын 14 өдөр мэргэжилтэн Хишгээ над руу утасдаж: Манай Түмэнбаяр дарга танайд 1 хоног өгье хувьцааныхаа арилжааг хийж дуусгах уу гэж байна гэсэн. Тэгэхэд би 1 хоногт бол тэргүүн ээлжинд худалдаж авах эрх хэрэгжүүлж байгаа этгээдүүдийн арилжааг л хийх байх. Уг нь журмаараа үнэт цаасыг нийтэд санал болгон арилжиж эхлэх өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай байдаг, манайх бас 1 сар өгөх байх гэж тооцож байсан. Гэхдээ 1 хоног гэсэн асуудлаа манайд албан ёсоор бичгээр зөвшөөрлөө өгөх байлгүй дээ гэж хэлсэн. Хувьцааныхаа арилжааг амжилттай хийж дуусган дараагийн 150 000 000 ширхэг хувьцааны зөвшөөрлийг авах хэрэгтэй байсан тул би тэр өдөрт нь 1 сарын хугацаанд арилжаагаа хийж дуусгах боломж хүсэн 2016 оны 06-р сарын 14 өдрийн 16/65 тоот албан бичгийг СЗХ-нд хүргүүлсэн.

Бидэнд арилжаа эхлүүлэх зөвшөөрлийг өгнө гэсэн итгэл маань алдарахгүй байсан тул МХБ болон ҮЦТТТХТ ХХК-д манайх зөвшөөрлөө СЗХ-ноос арай аваагүй байна, хувьцаа авах хүсэлтэй иргэд хувьцаа эзэмшигчдэд энэ тухай зөвөөр тайлбарлан хамтарч



ажиллана уу гэсэн албан бичгийг /2016 оны 06-р сарын 16 өдрийн 16/66 тоот албан бичиг/ хүртэл явуулж МХБ руу утасдан хэлж тайлбарлаж байсан.

Ингээд бид тэргүүн ээлжинд хувьцаа худалдаж авах хүсэлт ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийнхээ болон шинээр хувьцаа худалдан авах захиалгыг биелүүлж арилжаа хийх боломжгүй болсон. Арилжаа хийхээр товлосон өдөр Гаули, Голомт секьюритис зэрэг компаниудаас манай утас руу утасдаж хувьцааны арилжаа чинь яасан бэ хүмүүс сонирхож байна гэж асууж байсан.

Ингээд Санхүүгийн Зохицуулах Хороо 2016 оны 06-р сарын 22 өдрийн 3/2161 тоот албан бичгээр биднийг үнэт цаасны танилцуулгаа дахин бүртгүүлнэ үү гэж мэдэгдсэнийг бид СЗХ хугацаандаа арилжаа эхлүүлэх зөвшөөрөл өгөөгүй болхоороо бидэнд 3/2161 тоот албан бичгийг хүргүүлсэн байна гэж ойлгон холбогдох бичиг баримтыг хүргүүлэн хорооны 07-р сарын хурлаар орсон. СЗХ бидэнд арилжаа эхлүүлэх зөвшөөрөл олгосонгүй гэж бид тухайн үед гомдол гаргаж байгаагүй. Учир нь тухайн үед болон 2016 оныг дуустал бидэнд уг төлөвлөсөн хөрөнгийг татах боломж бүрэн байсан.

Санхүүгийн Зохицуулах Хорооны хурлаар хэлэлцээд сарын дотор хууль, үнэлгээ, аудитын шинэчлэгдсэн дүгнэлтүүдийг хороонд 2016 оны 08-р сарын 29-ний дотор дахин ирүүлснээр манай нэмэлт хувьцааны асуудлыг хамгийн эхний хурлаар шийдвэрлэж 6-н сарын хугацаанд хөрөнгөө татах боломжийг олгохоор болсон юм. /Санхүүгийн Зохицуулах Хорооны 2016 оны 07-р сарын 29-ны өдрийн 6/2498 тоот албан бичиг, 2016 оны 07-р сарын хорооны хуралдааны тэмдэглэл/

Үүний дагуу бид танайд 2016 оны 08-р сарын 12 өдөр аудит, үнэлгээний дүгнэлт, 2016 оны 08-р сарын 15 өдөр И-Эл-Си ХХН-ийн хуулийн дүгнэлтийг тус тус хүргүүлсэн. Бид СЗХ-ны мэргэжилтнүүд шалгах хангалттай цаг хугацаатай байгаасай гэж хүсэн өөрөөс хамаарах бүхий л арга хэмжээг аван, дүгнэлтүүдээ гаргуулан эх хувиар нь хүртэл өгсөн. Үүнээс хойш би Түмэнбаяр даргатай 2 удаа биеэр очиж уулзахад надад яагаад шийдэхгүй байгаа тухай нэг ч тайлбар хэлж байгаагүй. 2016 оны 08-р сарын 25 өдөр Үнэт цаасны газрын дарга Цэрэнбадралтай СЗХ-ны гадаа тамхилаад зогсож байхад нь уулзаж нөхцөл байдлаа танилцуулан гуйхад тэрээр: Тэргүүн ээлжинд худалдаж авсан хувьцааг амжилттай арилжсанд тооцохгүй, тэгэхээр танайх зарж чадахгүй угаасаа амжилтгүй болох байсан юм байна гэсэн хариу өгсөн.

Үнэт цаасны газрын дарга Цэрэнбадрал ямар ч үндэслэлгүй хариу хэлж байхад би эсэргүүцээгүй харин ч манай салбарыг хариуцсан даргынх нь хувьд айж эмээн, хүндэтгэн асуудлыг маань шийдээд өгөөч, бид Монголоос хөрөнгө татах биш, гадны хөрөнгө оруулагчдаас ихэнхи хөрөнгөө татна, зах зээл дээр манай нэр хүнд унаад байна гэж шалдаа буун өчнөөн гуйсан. Тэрээр за байз тэгвэл танайх нэмж гаргаж буй хувьцаагаа олон нийтэд танилцуулсан гэдгээ нотлох баримтаа явуул гэж хэлсэнийг үнэхээр тодоос тод санаж байна. Яагаад гэвэл энэ үйлдэл нь юу нэхдэг юм билээ? Яах вэ байз гэж байгаа мэт санагдаж, надад эвгүй байдлаар гүн сэтгэгдэл үлдээсэн юм. Түүний шаардсан зүйл бидэнд бэлэн байсан тул 2016 оны 08-р сарын 26 өдөр 16/96 тоот албан бичгээр хүргүүлсэн болно. Үүнээс хойш бид СЗХ-нд удаа дараа албан бичиг явуулсан боловч нэг ч бичигтээ хариу авч байгаагүй, очоод уулзахаар юу нь болохгүй байгаа, яагаад шийдэхгүй байгаа, бид юу засах, тодруулах, нэмэх шаардлагатай тухай юу ч хэлж, бичиж, сануулж байгаагүй.

Бид мөн энэ хугацаанд “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн удирдлагуудтай удаа дараа уулзаж байсан. Тэд 2016 он гарсан тул шинэ журам үйлчилнэ танайх дахиад материалаа бүрдүүлж өг гэсэн шаардлага тавьсан. Бидний бүрдүүлж өгсөн материалыг бүртгэлийн хэлтэсийн мэргэжилтэн Амартүвшин шалгаж байгаад танай шаардах эрхээр хувьцаа буцаан худалдан авах үнэ чинь хамаагүй бага байна энэ үнээ өсгө гэсэн шаардлага утсаар тавьсан. Энэ нь хуулийн дагуу тогтоосон шаардах эрхийн үнийг ТУЗ тогтоосон,

шаардах эрх хэрэгжүүлэх хугацаа нь дууссан, үнэт цаасны танилцуулгаас зөрнө гэж хичнээн тайлбарлаад ч нэмэр болоогүй. Энэ асуудлыг Монголын Хөрөнгийн Биржийнхэн урьд нь өөрийн шалгаад болно гээд тушаалаа гаргасан байсан асуудлаа үгүйсгэж дахин өөр шаардлага тавьж эхэлсэн юм. Бид буцаан худалдаж авах үнийг өсгөх боломжгүй байгаа тухай 2016 оны 08-р сарын 24 өдөр 16/93 тоот албан бичиг хүргүүлсэн ч тусыг эс олсон. МХБ ХК-ийн бүртгэлийн мэргэжилтэн Амартүвшинтэй утасаар муудалцаж хүртэл үзсэн. Ингээд манай компани үнэхээр хүчин мөхөсдөж 2016 оны 08-р сарын 29 өдөр 16/97 тоот албан бичигтээ "... бид нэмж хувьцаа гаргах ажиллагааг амжилттай явуулах цаг алдахгүй байх үүднээс танай шаардлагыг хүлээн авч шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийн нэгж хувьцааг эргүүлэн худалдан авах үнээ 100 /нэг зуун/ төгрөгөөр шинэчлэн тогтоосон тогтоолоо хүргүүлж байна" гэж бичин хүргүүлсэн.

Үүний дараа Монголын Хөрөнгийн Биржийн захиралын туслах эмэгтэй Болор захирал тантай уулзъя гэж байна та 2 цагт ирээрэй гэж хэлэхэд очсон. Захирал байхгүй гаднаас /Балбын гэсэн байхаа/ хүмүүс ирсэн тэд нартай ажилтай болчихлоо гээд бүртгэлийн албаны дарга Тогтохбаяр, Аззаяа нар надтай уулзаж ярилцсан.

Тэд танай хугацаа дууссан, шинэ журмаар хувьцааныхаа материалаа дахиад манайхаар хянуулж байгаа тул тэмдэгтийн хураамжийн 2 сая төгрөгийг дахиад төлөх хэрэгтэй гэсэн. Энэ асуудлыг бол үнэхээр хүлээн зөвшөөрөх боломжгүй байсан. Учир нь МХБ ер нь юу хийсэн бэ? Захирлынхаа тушаалыг арилжаа эхлүүлэхэд татгалзах зүйлгүй гэсэн тодорхойлолтын хамт СЗХ-нд хүргүүлэх байсныгаа ч мэдэхгүй байсан. Тухайн үед би манай гаргаж байгаа хувьцааг монголоос бараг хүн авахгүй, гадны хөрөнгө оруулагчид л авна гэдэгтээ санал нэг байсан. Уулзалтын эцэст Тогтохбаяр Санхүүгийн Зохицуулах Хорооны нэмэлт хувьцаа гаргахыг зөвшөөрсөн тогтоол болон манай Гүйцэтгэх захирлын тушаал хүчинтэй байгаа тул СЗХ-ноос нэмэлт хувьцаа гаргах асуудлыг сэргээсэн тогтоол аваад ирвэл манайх ямар ч асуудалгүй, дахиж танилцуулгыг чинь ч хянах хэрэггүй. Цаг хугацаа хэмнэнэ гэсэн шийдэлд хүрсэн. Маргааш нь Болор захиралтай уулзахад манайхаас 2 сая төгрөгийг дахин авахгүй гэдгээ албан ёсоор хэлсэн болно.

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн Бүртгэлийн хэлтэсийн дарга н.Тогтохбаяртай 2016 оны 10-р сарын 13 өдөр Гүйцэтгэх Захирал Г.Оюунболд миний бие утсаар ярьж Хороо нэмэлт хувьцаа гаргах тогтоолыг сэргээж өгсөн тохиолдолд цаг хугацаа хэмнэх, олон шатлалтай ажлыг хөнгөвчлөх, хөрөнгө татах ажлыг түргэвчлэх боломжтой байгаа тухай ярилцан тохиролцсоныхоо дагуу байр сууриа СЗХ-нд илэрхийлж өгөөч гэж гуйхад "... Хорооноос манайд өнөөдөртөө багтааж албан бичиг ирнэ гэсэн арилжаа эхлүүлэх зөвшөөрлийн бичгийг танайх хэрхэн бичсэн тухай бид ярилцана, танайх манайд арилжаа эхлүүлэх хүсэлтээ өгөхдөө *"... арилжаа эхлүүлэх нөхцөл байдал хангагдсан, татгалзах зүйлгүй тухай тодорхойлолт авъя"* /ийм утгатай хэлсэн, албаны үгээр хэлсэнийг нь яг нэг бүрчлэн санахгүй байна. зарим нэг үг нь энд өөрөө бичигдсэн байх магадлалтай/ гэж бичээгүй юм байна гэж хэлсэн. Энэ бол танай асуудал, би танайд албаны үг хэллэгээр бичээгүй ч гэсэн хэндч ойлгогдохоор бичсэн. Яг энэ үг бичигдээгүй байна гэдэг бол үнэхээр утгайгүй. Тэгвэл та нар албаны үгээр бичих заавраа цахим хуудас дээрээ загвар болгоод тавихгүй яасын бэ хэлээд утасны яриа дууссан. Үүнээс хойш манайд ямар ч хариу тайлбар МХБ ХК-аас ирүүлээгүй. Бид шинэ журмын дагуу МХБ-д өгөх танилцуулгыг бэлдсэн өгөхөд бэлэн байгаа тухайгаа ч хэлсэн. Сүүлд Тогтохбаяр даргатай ярихад Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрийг хүлээж байна гэхээс өөр юу ч хэлээгүй болно.

Үнэхээр манай компани хууль бус зүйл хийсэн, бидний алдаа байсан юм бол Төрийн ордонд болсон Нэг шийдэл, Нэг Зорилго хэлэлцүүлгийн үеэр намайг нөхцөл байдлаа тайлбарлаж байхад Үнэт цаасны газрын дарга Цэрэнбадрал олон хүмүүсийн өмнө манай асуудлыг няцаан, алдааг минь хэлж өөрсдийгөө хамгаалах байсан. Цэрэнбадрал

дарга Багануурт хариу тайлбар хэлсэн мөртлөө харин манай асуудал дээр юу ч хэлж чадахгүй байсан.

Бид санхүүгийн Зохицуулах Хороонд 2016 оны 07-р сараас хойш өчнөөн олон удаа албан хүсэлт явуулсан боловч нэг ч хариу аваагүй байж байгаад 2016 оны 12-р сарын 13 өдөр 5/3603 тоот албан бичиг хүлээн авсан.

Энэ олон сарын хугацаанд нэг ч хариу авалгүй байж байгаад монгол хэлний үг үсгийн болон утга, найруулгын алдаатай, албан бичигт дурьдсан зарим хуулийн зүйл заалт нь тухайн асуудалтай ямар ч хамааралгүй /ҮЦЗЗТХ-ийн 24.1.5, 25.1.1/, бидний хөндөж тавиад байгаа асуудалд хариу өгч, биднийг няцааж чадахгүй, өөрсдийнхөө буруутайг улам нотолсон, бидний бизнесийн нэр хүндэд ноцтойгоор халдаж манай мэргэжилтнүүдийг гутаан доромжилсон албан бичгийг хүлээн авсан.

Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны газрын дарга нь арилжааг эхлүүлж өгөөч гэж хуулийн хугацаанд гаргасан бидний хүсэлтийг шаардлага хангаагүй гэж үзээд зөвшөөрөл олгоогүйгээ уг албан бичигт дараах байдлаар тайлбарласан байсан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2-т “Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг Хороо олгох бөгөөд Хороо уг зөвшөөрлийг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай хөрөнгийн биржээс гаргасан тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн олгоно гэсэн шаардлагыг хангаагүй буюу тус компанийн нэмж гаргасан хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг явуулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан тухай “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн тодорхойлолтыг ирүүлээгүй... тул.

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2, СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.2.3, 3.2.7 болон “МХБ” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 8.2 заалтуудын дагуу тус компанийн нэмж гаргах хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг явуулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан тухай тодорхойлолтыг явуулах үүрэг хүлээсэн этгээд нь манай компани биш харин “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК юм.

“МХБ” ТӨХК –ийн гүйцэтгэвэл зохих үүргийг манайхаас шаардаж байгаа нь хууль бус бөгөөд “МХБ” ТӨХК –ийн дотоод үйл ажиллагааг бид мэдэхгүй. Бидэнд зөвхөн нэмж гаргаж буй хувьцааг бүртгэхийг зөвшөөрсөн захирлын тушаалаа л өгсөн.

Манай хөрөнгө оруулагчид 2016оны 07-р сараас хойш зардал гарган байж манай нэмэлт хувьцааны асуудлыг асуун, биднийг найдвартай эсэхийг шалган бидэн руу утасдаж бүр Монголд өөрийн биеэр хүртэл ирж байсан. Энэ ирэх болгонд нь бид ямар ч хариу тайлбаргүй, үзүүлэх нэг ч бичиггүй байдаг учираас танайхаас СЗХ-ноос хариу хүсэж бичиг хүргүүлж байсан.

Гэтэл СЗХ хариу тайлбартаа: *“Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн нэмж гаргасан энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасах асуудлыг 2016.09.21-ний өдрийн болон 2016.10.18-ний өдрийн Хорооны ээлжит хуралдаанд танилцуулахаар төлөвлөж боловч тус компаниас 2016.09.16-ний өдрийн 16/100, 2016.10.14-ний өдрийн 16/102 тоот албан бичгүүдээр ирүүлсэн хүсэлтийг судлан үзэх үүднээс дээрх өдрүүдэд хуралдсан Хорооны хуралдаанд танилцуулах ажлыг хойшлуулсан гэсэн хариу өгсөн.*

Өнгөрсөн саруудад бидний хүргүүлж байсан албан бичгүүд: манай асуудлыг нааштайгаар шийдэж өгөөч, хувьцаагаа гаргаж гадны хөрөнгө оруулагчдаас монголдоо хөрөнгө татахад туслаач гэсэн нэг л утгатай байсан.

Үнэхээр СЗХ хүчингүй болгохоор төлөвлөж байсан юм бол биднийг нэг утгатай албан бичиг өгөх болгонд л дахиад судъя гэж олон сараар хойшлуулж байсаныг бид 2016 оны 07-р сараас хойш СЗХ манай асуудлыг ямар нэгэн шалтгаанаар шийдвэрлэхийг огт

хүсээгүй, үнэхээр үхлийн ирмэгт байгаа Монголын Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхийн төлөө өчүүхэн ч сэтгэл гаргаж ажиллаагүй, албан бичгийн хариуг ч өгч чаддаггүй үнэт цаасны удирдлагатай гэдгээ нотлон харуулсан.

Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын томилсон Шалгалтын ажлын хэсэг тус компани дээр 2016 оны 12-р сарын 09 өдрөөс 2016 оны 12 сарын 12 өдрийн хооронд газар дээрх шалгалт хийгээд манайд тайлангаа 2017 оны 01-р сарын 09 өдөр хүлээлгэн өгсөн.

Уг шалгалтын тайланд бас л манайхыг арилжаа эхлэхэд бэлтгэл хангагдсан тухай тодорхойлолтыг хүргүүлээгүй байна гэж бичиж “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК –ийн биелүүлвэл зохих үүргийг биднээс шаардсан байсан. Гэтэл СЗХ-ны Үнэт цаасны газрын удирдлагууд 2016 оны 07-р сараас хойш 2017 оны 01-р сар хүртэл юу ч хийгээгүй талаар нэг ч үсэг, үг, өгүүлбэр бичээгүй байсан. Яг үнэндээ бид манай арилжаа эхлүүлэх зөвшөөрлийг 3 хоногт өгөөгүйд биш харин 2016 оны 07-р сараас 2017 оны 01-р сарын 31-ний өдөр хүртэл 6 сарын хугацаанд юу ч хийгээгүйд, бидэнд дорвитой хариу өгч байгаагүйд гомдолтой байгаа.

Шалгалтын тайлангийн 21-р хуудас буюу дүгнэлт хэсэгт: “Евразиа Капитал Холдинг” ХК-ийн танилцуулгыг шинэчлэн бүртгэх нь зүйтэй байна... гэснийг бид Санхүүгийн Зохицуулах хороо бидний шинэчлэн бүртгүүлэхээр хүргүүлсэн байгаа материал, хөндлөнгийн дүгнэлтүүдийн хүрээнд бүртгэх / бид бүртгүүлэхээр дахин дүгнэлтүүд хүргүүлэх шаардлагагүй/ юм байна гэж ойлгон хүлээцтэй хандаж байтал: 2017 оны 01-р сарын 17 өдрийн 3/151 тоот Санхүүгийн Зохицуулах Хорооны ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Жамбаажамцын гарын үсэг бүхий албан бичгийг хүлээн авсан. Өөрөөр хэлбэл энэ нь 2016 оны 07-р сараас хойш СЗХ-ноос бидний хүлээж авсан сүүлийн буюу 2-дох албан бичиг байлаа. Уг албан бичигт биднийг хууль болон холбогдох журмыг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэйг мөн шинэчилсэн үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгыг хороонд ирүүлнэ үү гэжээ.

Бид СЗХ-ны 2016 оны 6-р сарын 22 өдрийн 3/2161 тоот албан бичгийн дагуу үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгыг аль түрүүн буюу 2016 оны 07-р сард буюу 6 сарын өмнө СЗХ-нд хүргүүлчихээд байгааг ч мэдэхгүй байгаад гомдолтой байна.

Манай сүүлд хүргүүлсэн үнэт цаасны танилцуулгыг дахин шалгана гэдгээ Үнэт цаасны дарга Цэрэнбадрал нь 08-р сарын 25 өдөр СЗХ-ны гадаа уулзахдаа надад хэлж байсан. Шалгасан ч байх гэж бодож байна. Одоо бас яагаад биднийг дахин ирүүл гэж цаг хугацааг алдагдуулж, биднийг хохироож байгааг үнэхээр ойлгохгүй байна.

2016 оны 07-р сарын Санхүүгийн Зохицуулах Хорооны хуралдаанаас хойш өнөөдрийг хүртэл буюу 2017 оны 01-р сарын 31 өдөр хүртлэх хугацаанд СЗХ-нд олон арван бичиг хүргүүлж, Төрийн Ордонд болсон Нэг Зорилго, Нэгдсэн Шийдэл хурал дээр хүртэл олон түмэн хүмүүсийн өмнө, Цэрэнбадрал даргын өмнө үгээ хэлж, шийдэж өгөөч гэж гуйж удаа дараа гуйж байхад тэдэнд шийдэх боломж, цаг хугацаа зөндөө байсан.

2016 оны 07-р сараас хойш шийдэж өгөхгүй байсаар өнөөдөр бидэнд 2 тэрбум төгрөгийн хохирол учруулаад байгаа этгээд бол Санхүүгийн Зохицуулах Хороо.

Санхүүгийн Зохицуулах Хорооны удирдлага өөрсдийн албан хаагчдаа шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл гаргасан байсан. Гүйцэтгэх Захирал Г.Оюунболд миний бие нь хоёр удаа Авлигатай тэмцэх газарт очиж тайлбар өгсөн. Өнөөдрийн байдлаар асуудал хэрхэн шийдвэрлэгдсэн тухай ямар ч мэдээлэл байхгүй байна.

Манай асуудлыг одоо ч шийдвэрлэж өгөхгүй, бидний сүүлд буюу 2017 оны 12-р сарын 27 өдөр өгсөн албан бичгийн хариуг өнөөдөр хүртэл өгөөгүй л байна. Бид СЗХ-ны албан ёсны хариуг хүлээсээр л байна.

Хувьцаа эзэмшигч “Мезза Файнэншл Групп” ХХК түүнийг төлөөлж Камоллиддин Талипов:

Энэ бол арай л дэндэж байна. Бүтэн жил өнгөрч байхад бас л ямар ч хариу байхгүй байгаа нь үнэхээр гайхалтай бөгөөд үнэхээр харамсмаар зүйл болж байна. Ингэж ажиллаж байж Монгол улс гаднаас хөрөнгө татана, гадны хөрөнгө оруулагчдыг дэмжинэ гэж байгааг үнэхээр ойлгохгүй байна. Яагаад одоог хүртэл асуудлыг шийдвэрлэхгүй байгаа нь маш их сонирхол татаж байна. Үнэхээр хэлэх ч үг алга.

“Омега Инвест” ХХК компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч:

Хувьцаа эзэмшигч “Омега Инвест” ХХК-ийн удирдамж болон хүсэлтийн дагуу санал өгч байна. Энэ асуудлыг шийдэхгүй удаж байгаад гүнээ харамсаж байгаагаа илэрхийлээд цаашид хувьцаа худалдаж авахгүй болсон тухайгаа албан ёсоор мэдэгдэж байгаагаа дамжуулж өгөхийг хүссэн. Мөн хуулийн юмуу зохих эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээд хариугаа бидэнд явуулахгүй бол бид танай компани болон удирдлагад итгэх итгэлээ алдаж байна гэсэн үг юм.

Хурлын дарга Г.Оюунболд:

- “Омега Инвест” ХХК асуудалд ингэж хандаж байгааг сайн ойлгож байна Би үнэхээр боломжоороо, бүхий л хүчээ дайчлан энэ асуудлын хойноос хөөцөлдөж байна. Үнэхээр төрийн байгууллагын өмнө хүчин мөхөсдөж байна.

Хувьцаа эзэмшигчид:

Гэм буруутай этгээдээр хохирлоо нөхөн төлүүлэх хэрэгтэй. Нэр төрөө сэргээлгэх хэрэгтэй.

Хурлын дарга Г.Оюунболд:

Бидний хэлэлцэх дараагийн асуудал бол “Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах” байгаа. Энэ асуудлыг та бүхэнд “Евразиа капитал холдинг” ХК – ийн Гүйцэтгэх захирал, компанийн хувьцаа эзэмшигч Г.Оюунболд би танилцуулна.

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ СТРАТЕГИ

Бизнесийн гадаад болон дотоод орчны хүчин зүйлс, зах зээлийн боломжуудад тулгуурлан бид өсөлтийн стратеги баримтлан ажиллах хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна. Одоогийн байгаа зах зээлд одоо үзүүлж байгаа үйлчилгээг чанартай үзүүлэх, шинэ бүтээгдэхүүн санал болгох замаар зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх, хуваарилалтын сувгийн хувьд тэлэх стратеги баримтлан ажиллах замаар бизнесийн өсөлтийг ханган ажиллахад чиглэнэ.




Бүтээгдэхүүн хөгжүүлэх стратегийн хүрээнд доорх бүтээгдэхүүнийг хөгжүүлэн харилцагчдад санал болгох замаар санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэхийг зорин ажиллана. Үүнд:

- Бизнес, санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
- Нийлэх, нэгдэх хэлцэлд зуучлагчаар оролцох
- Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ
- Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ
- Синдикат үйлчилгээ
- Эрсдэлийн менежментийн цогц үйлчилгээ
- Дотоод хяналтыг хийж гүйцэтгэх
- Хөрөнгийн удирдлагын үйлчилгээ

Бизнесийн стратеги

Зах зээлийн боломж, өсөлт болон үндсэн үйл ажиллагаанаас олох орлогын прогноз дээр тулгуурлан бизнесийн стратегийг дараах байдлаар тодорхойлж байна

Зураг 2 Үндсэн үйл ажиллагаанаас олох орлого, төгрөг



Ирээдүйд өсөлт хамгийн өндөр байх, орлого олох боломжтой үйл ажиллагааг брокер болон андеррайтерын үйл ажиллагаа гэж үзэж байгаа учраас эдгээр үйлчилгээг хөгжүүлэхэд нөөц боломжоо түлхүү ашиглан ажиллана.

Зэрэглэвэл:


- Хөрөнгө оруулалтын зөвлөх
- Андеррайтер
- Брокер, дилерийн үйл ажиллагаа
- Хурал зохион байгуулах

Үйл ажиллагааны стратеги дундаа маркетингийн стратегийг дараах байдлаар нарийвчлан тодорхойлов.

Маркетингийн стратеги

Компанийн ерөнхий стратеги, зорилго зорилт, бизнесийн стратеги дээр тулгуурлан ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зах зээл дээр эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн маркетингийн бодлого баримтална

Хүснэгт 1 Маркетингийн стратеги.



Бүтээгдэхүүний стратеги	Хөрөнгө оруулалтын зөвлөх, менежмент, санхүүгийн зөвлөх, хадгаламжийн бичиг, олон улсын хөрөнгийн бирж дээрээс дотоодын иргэдэд үнэт цаас арилжаалахад зуучлах гэх мэтчилэн санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн иж бүрэн үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэн ажиллана
Үнийн стратеги	Зах зээл дээр тулгуурласан үнийн стратеги
Хуваарилалтын сувгийн стратеги	Хуваарилалтын сувгийг тэлэх стратеги баримтална
Идэвхжүүлэлтийн стратеги	Push болон Pull стратегийг хэрэгжүүлнэ

Маркетингийн төлөвлөгөө

Үйлчилгээ

Компани дотоодын болон гадаадын байгууллага болон хувь хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын банкны бүх төрлийн үйлчилгээг үзүүлэхийг зорин ажиллаж байна. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд үйл ажиллагаагаа 3 шатаар төлөвлөж ажиллаж байна. Компани 2008 онд брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авч ажиллаж байсан бөгөөд төлөвлөгөөний дагуу 2009 онд андеррайтерийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан.

Одоогоор бид дараах үйл ажиллагаануудыг явуулж байна. Үүнд:

- Брокерийн үйл ажиллагаа
- Дилерийн үйл ажиллагаа
- Андеррайтерийн үйл ажиллагаа
- Хөрөнгө оруулалтын зөвлөх

Ирээдүйн гурван жилийн хугацаанд бид бизнесийн болон санхүүгийн зөвлөгөө өгч, нийлэх нэгдэх (M&A) үйл ажиллагаануудад зуучлагчаар оролцож хөрөнгө оруулалтын банкны иж бүрэн үйлчилгээг үзүүлнэ. Мөн эдгээрээс гадна хувийн хөрөнгө оруулалтын үйлчилгээг үзүүлнэ.

- Бизнес, санхүүгийн зөвлөгөө
- Нийлэх нэгдэх, худалдан авах хэлцэлд зуучлагчаар оролцох
- Хувийн хөрөнгө оруулалт
- Хадгаламжийн бичиг гэх зэрэг

Бидний эдгээр бүх үйлчилгээ эдийн засаг, салбар, компаниудын нарийвчилсан судалгаан дээр үндэслэж явагдах учраас судалгааны үйл ажиллагаа бүх шатанд маш чухал бүрэлдэхүүн хэсэг байх болно. Бид байгуулагдсан цагаасаа хойш Монгол улсын эдийн засаг, голлох салбарууд болон компаниудын судалгааг бэлтгэж олон нийтэд нээлттэйгээр танилцуулж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаа компанийн болоод хөрөнгийн зах зээлийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байгаа гэж бид үзэж байгаа юм.

Зах зээл, түүнд эзлэх компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Бид дараагийн жилүүдэд үндсэн үйлчилгээнээс олох орлогын төлөвлөгөө гаргахын тулд ДНБ-ний төсөөлөл дээр суурилан, хөрөнгийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүдийг дараах байдлаар тооцоолоод байна.

	2017	2018E	2019E	2020E
ДНБ	16,873	16,711	17,563	18,441
Арилжааны хэмжээ	219	306	428	556.4
Зах зээлийн үнэлгээ	2,440	2,558	2,676	2,756
Зах зээлийн үнэлгээ/ДНБ харьцаа	14.46%	15.31%	15.24%	14.95%
Зах зээлийн эргэлт/Үнэлгээ харьцаа	8.98%	11.96%	15.99%	20.19%

Компани нь 2011 онд арилжааны дүнгээрээ зах зээлд 2-рт орж байсан бол 2017 онд манай компани нийт 219 сая төгрөгийн арилжаа хийж үнийн дүнгээр 17 жагсаж орсон байна. Зах зээлийн үнэлгээ нэмэгдсэнтэй холбогдуулан манай компани арилжааны хэмжээгээ нэмэгдүүлж 2018 онд 306 саяд хүргэх зорилготой байна.

Дараагийн жилүүдэд хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор Монголын хадгаламжийн сертификатын арилжааг нэвтрүүлэх, дотоодын томоохон компаниудын хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, Монголд үйл ажиллагаа явуулдаг олон улсын компаниудын хувьцааг Монголын хөрөнгийн зах зээлд давхар бүртгүүлэх ажлуудыг амжилттай хийхийн тулд компаниуд, хөрөнгийн биржүүдтэй нягт хамтран ажиллана.

“Евразиа Капитал Холдинг ҮЦК” ХК нь хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх эрх 2011 онд авсан. Банкны зээлийн хүү асар хурдтай өсөж, хувьцааны санхүүжилт өсөж буй энэ үед Монголын компаниудын хувьд үйл ажиллагаагаа амжилттайгаар үргэлжлүүлэн явуулахын тулд зөвхөн банкны зээлд найдаж суух биш цаашид гадаадын шууд хөрөнгө оруулалтанд анхаарах шаардлага үүсэж байна. Энэ шаардлагын дагуу засгийн газраас хууль, эрх зүйн орчны хувьд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах таатай нөхцөл бололцоог бүрдүүлж өгсөн. Сүүлийн 2 жилд гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан ч ирээдүйд урьд жилүүдээс илүүгээр өсөх магадлалтай. Энэхүү гадаадын шууд хөрөнгө оруулалтыг амжилттай олж гадаадын хөрөнгө оруулагчидтай холбоо тогтоож, амжилттай хэлэлцээр хийхэд Монголын компаниуд зөвлөгөө авах шаардлага байгаа бөгөөд энэхүү зөвлөхийн үйлчилгээг “Евразиа Капитал Холдинг ҮЦК” ХК хүргэхээр ажиллаж байна.

Энэ зах зээлд тавьж буй зорилгоо хэрэгжүүлэхийн тулд манай компани дараах стратегийг баримтлан ажиллахаар төлөвлөөд байна. Үүнд:

- Стандартад нийцсэн хөрөнгө оруулалтын илтгэл бичих, компанийн нарийвчилсан судалгаа (due diligence) хийх болон бизнес төлөвлөгөө бичихэд нь Монголын компаниудад зөвлөгөө өгөх
- Компанийн зүгээс тодорхойлж буй бизнесийн стратегийн төлөвлөгөө болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд дээр суурилан хөрөнгө оруулагчдын сонирхолд нийцэхүйц өсөлтийн стратегийг зөвлөх
- Хямдруулсан мөнгөн урсгалын шинжилгээ, харьцуулсан шинжилгээ зэрэг олон улсад өргөн хэрэглэгддэг стандарт аргуудаар компанийн үнэлгээ, судалгаа, хөрөнгө оруулалт хийх
- Хөрөнгө босгох аль оновчтой хувилбарыг зөвлөх (бонд гаргах, зээл авах, хувьцаа эсвэл төрөл бүрийн хөрвөх үнэт цаас гаргах гэх мэт)

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулах
- Хөрөнгө оруулагчдын чанарыг үнэлж, хөрөнгө оруулалтын нөхцөлийн талаар хөрөнгө оруулагчид болон компаниудтай хэлэлцэх.
- Хадгаламжийн сертификатын үйлчилгээг (depository receipts) нэвтрүүлж, зөвлөгөө өгөх. Ингэснээр гадаад зах зээл дээр хадгаламжийн сертификатыг гаргах шаардлагыг хангаж буй дотоодын хувьцаат компаниуд гадаад хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалах боломжтой болж байгаа юм.
- Монгол болон гадаад улсад бүртгэлтэй хувьцаат компанийг Монгол, гадаад улсын хөрөнгийн биржид зуучлан давхар бүртгүүлэхэд (dual-listing) зөвлөгөө өгөх замаар гадаад дотоодын харилцагчдыг татах
- Компанийг нэгтгэх, хуваах, өөрчлөх (mergers and acquisitions) үйлчилгээ нэвтрүүлэх

Бид хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх үйлчилгээгээ хоёр талын гэрээн дээр үндэслэн явуулах бөгөөд 2018-2022 оны хооронд жилд арваас доошгүй компанид хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг үзүүлнэ хэмээн төлөвлөгөө боловсруулаад байна. Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний орлого болон дилерийн үйл ажиллагааны орлогуудыг дараах хүснэгтэнд тусгаснаар таамаглалаа.

Хүснэгт 3 Хөрөнгө оруулалт болон дилерийн үйл ажиллагаа, сая төгрөг

	2018E	2019E	2020E	2021E	2022E
Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний орлого	10	12	15	19.5	23.4
Дилерийн үйл ажиллагааны орлого	20	24	30	39	46.8

Үйлчлүүлэгч, харилцагчид

Компани нь гадаадын зах зээлд чиглэх үйл ажиллагаандаа гадаадын худалдан авах тал (buy-side)-ын байгууллагын хөрөнгө оруулагчид, түүний дотор сангийн менежментийн харилцагчдыг татах бодлогыг баримтална. Ингэснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлд байгууллагын хөрөнгө оруулагчдыг түлхүү татаж, багцын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бөгөөд салбарын хөгжилд хувь нэмэр оруулах болно.

Хүснэгт 4 Брокерийн үйлчилгээний зорилтот үйлчлүүлэгчид

Гадаад	Дотоод
• Байгууллагын хөрөнгө оруулагчид • Хөрөнгө оруулалтын сангууд • Хедж сангууд • Багцын сан /Equity fund/ • Хөгжлийн сангууд • Хувь хүн	• Хувь хүн • Компаниуд

АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Андеррайтерийн үйлчилгээний хувьд бид дараах салбарын компаниудын хувьцааг хөрөнгийн биржид зуучлан борлуулахад түлхүү анхааран ажиллах болно. Үүнд:

- Уул уурхай

- Барилгын материал
- Дэд бүтэц
- Аялал жуулчлал
- Интернет, Шуудан Холбоо

Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний хувьд мөн дээрх салбаруудын компаниудад голлон үйлчилгээ үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

ХАДГАЛАМЖИЙН БИЧИГ

“Евразиа Капитал Холдинг ҮЦК” ХК нь үнэт цаасны тухай хуулиар зөвшөөрөгдсөн хадгаламжийн бичгийн үйлчилгээг Монгол Улсад анх удаа хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулаад байна. Компанийн гүйцэтгэх удирдлагууд Монголын хөрөнгийн зах зээл дээр шинэ бараа бүтээгдэхүүн болон хадгаламжийн бичгийг төлөвлөгөөний дагуу гаргахаар дэлхийн тэргүүлэгч хөрөнгө оруулалтын банк болох BNY Mellon банкны төлөөлөгч нартай уулзаж хамтран ажиллах талаар зөвшилцсөн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Өнөөгийн үйл ажиллагааны нөхцөл байдал

Евразиа Капитал Холдинг нь цаашид тус компани нь үйл ажиллагаагаа өргөжүүлж илүү олон харилцагчийг татах замаар зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлнэ. Компанийн зүгээс брокер, дилерийн үйл ажиллагааны арилжааны шимтгэлийг бууруулах сонирхолтой байгаа боловч шимтгэлийн ихэнх хувийг зохицуулах байгууллагууд авч байгаа нь бууруулах боломжийг багасгаж байна. Мөн андеррайтерийн эрх авсантай холбогдуулан бонд болон хувьцаа гаргах замаар санхүүжилт босгох сонирхолтой компаниудтай хамтарч ажиллах бөгөөд хүснэгтэд заасан шимтгэлийн хувь хэмжээг баримталж ажиллана.


Хүснэгт 5 Цаашид баримтлах шимтгэлийн хувь хэмжээний төсөөлөл

	2018	2019	2020	2021	2022
Андеррайтинг (анхдагч зах зээл)	3.00%	3.00%	3.00%	3.00%	3.00%
Брокерийн үйлчилгээ	2.00%	2.00%	2.00%	2.00%	2.00%
Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ	2-5%	2-5%	2-5%	2-5%	2-5%

Орлогын төлөвлөгөө

Зах зээлийн төлөвлөгөөнд дурдсан зорилтот үйлчлүүлэгчид болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд дурдсан шимтгэлүүдээс уялдан манай орлогын ойрын 5 жилийн төлөвлөгөө дараах байдалтай байхаар байна.

Зураг 3 Үндсэн үйл ажиллагаанаас олох орлого, төгр



Хүснэгт 6 Орлогын таамаглал, төгрөг

	2018E	2019E	2020E	2021E	2022E
Орлого	102,500,000	116,500,000	138,400,000	167,785,000	196,477,750
Андеррайтерийн үйл ажиллагаа	60,000,000	66,000,000	75,900,000	87,285,000	100,377,750
Брокерын үйл ажиллагаа	10,000,000	12,000,000	15,000,000	19,500,000	23,400,000
Дилерийн үйл ажиллагаа	20,000,000	24,000,000	30,000,000	39,000,000	46,800,000
Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ	10,000,000	12,000,000	15,000,000	19,500,000	23,400,000
Хурал зохион байгуулах	2,500,000	2,500,000	2,500,000	2,500,000	2,500,000
Зардал	86,765,000	87,467,000	89,903,190	90,754,991	93,888,156
Цалингийн зардал	64,500,000	64,500,000	66,000,000	66,000,000	68,000,000
Нийгмийн даатгалын шимтгэл	7,095,000	7,095,000	7,260,000	7,260,000	7,480,000
Зар сурталчилгааны зардал	1,250,000	1,275,000	1,300,500	1,326,510	1,353,040
Шуудан холбооны зардал	4,100,000	4,223,000	4,349,690	4,480,181	4,614,586
ҮЦТХГ-д төлөх шимтгэл	400,000	400,000	400,000	400,000	400,000
МХБ-ийн гишүүний хураамж	3,100,000	3,100,000	3,100,000	3,100,000	3,100,000
МХБ-ийн 0.4% шимтгэл	120,000	144,000	180,000	234,000	280,800
Тээврийн зардал	3,350,000	3,685,000	4,053,500	4,458,850	4,904,735
Сургалтын зардал	900,000	900,000	900,000	900,000	900,000
Бусад зардал	1,950,000	2,145,000	2,359,500	2,595,450	2,854,995
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	15,735,000	29,033,000	48,496,810	77,030,009	102,589,594
Татварын зардал	1,573,500	2,903,300	4,849,681	7,703,001	10,258,959
Цэвэр ашиг/алдагдал	14,161,500	26,129,700	43,647,129	69,327,008	92,330,634

Та бүхэнд асууж тодруулах зүйл байвал санаа зоволтгүй асууж болно.

Хувьцаа эзэмшигчид:

- Асуух зүйл байхгүй.

ТУЗ-ийн дарга Б.Отгонтуяа:

- Ногдол ашиг тараахгүй гэж шийдвэрлэсэн шийдвэрийг та бүхэн танилцуулж байна. Энэ компанийг өнгөрсөн хугацаанд ашиггүй ажиллуулах гол нөхцлийг бүрдүүлсэн зүйл бол татан төвлөрүүлэх байсан хөрөнгийг шийдэж өгөөгүй удсанд байгаа юм.

Хурлын дарга Г.Оюунболд: Бидний өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудалд багтсан бусад гэх асуудлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох байгаа. Та бүхэнд тарааж өгсөн танилцуулгыг уншиж танилцан асуулт асуух боломжтой. Та бүхэнд өөр хэлж ярих зүйл байвал чөлөөтэй илэрхийлж болно.

Хувьцаа эзэмшигчдийн санал хүсэлтийн дараа саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсний дараа хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

“Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна” хэмээн Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Б.Өлзийбаяр танилцууллаа.

“Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн 2018 оны 4 сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. ТУЗ-өөс хуралд оруулж ирсэн компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дэмжин батлав.
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.
3. Бусад асуудлын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан, компанийг хохиролгүй болгох асуудлыг бүрэн шийдвэрлэхийг ТУЗ-д үүрэг болгон зөвшөөрөв.

Хурлын дарга Г.Оюунболд хурлыг хаав.

Хурал: 14 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн.

Хянасан:

Хурлын дарга:



Э.Саранчимэг

Г.Оюунболд